



**МОНГОЛБАНК
СУДАЛГАА, СТАТИСТИКИЙН ГАЗАР**

**ГАДААДАД АЯЛЖ БУЙ МОНГОЛ ЖУУЛЧДЫН ЗАРДЛЫН
ТҮҮВЭР СУДАЛГАА**

Хураангуй

Төлбөрийн тэнцлийн статистикийн аялал жуулчлалын дансны зарлагын гүйцэтгэлийг тооцохын тулд Монгол жуулчдын гадаадад аялахдаа зарцуулж буй дундаж зардлыг тодорхойлох зорилгоор энэхүү түүвэр судалгааг гүйцэтгэв.

Түүвэр судалгаанд гадаадад аялсан **936** зорчигчийг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулснаас гадна Монгол Улсад аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 15 аж ахуйн нэгжээс асуулгын аргаар тоон мэдээллийг авч, нэгтгэн тооцсон бөгөөд судалгааны гол үр дүнгээс дурдвал, Монгол жуулчид гадаадын улсад дунджаар **12** хонох хугацаандаа **1,576** ам.долларыг зарцуулдаг байна.

I. ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Төлбөрийн тэнцлийн статистикийн хамрах хүрээ, мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд 2017 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Аялал жуулчлалын хөгжлийн төв (АЖХТ)-тэй хамтран “Монгол улсын аялал жуулчлалын орлого, зардлын судалгаа”-г асуулгын аргаар зохион байгууллаа. Судалгааг гадаадад аялсан Монгол жуулчид болон дотоодын жуулчдад үйлчилгээ үзүүлдэг тур оператор компаниудаас авсан мэдээлэлд үндэслэн тооцож, үр дүнг танилцуулж байна. Судалгааны асуулгыг тараах, цуглуулах ажилд АЖХТ, БОАЖЯам, ХХЕГ, УБТЗ ХНН, МИАТ ХК болон МАЖХолбоо, түүний гишүүн байгууллагуудтай хамтран ажиллаа.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ


2.1. Судалгааны зорилго

Төлбөрийн тэнцэл дэх жуулчлах зорилготой аяллын үйлчилгээний зардлыг Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ)-аас ирүүлдэг жуулчлах зорилгоор гадаадад аялсан зорчигчдын тоон мэдээлэлд тохируулга хийн Монголбанкнаас 2005, 2014 оны судалгаагаар тооцсон дундаж зардлын дүнгээр үржүүлэн тооцож байна.

Гадаад, дотоодын инфляцийн түвшин ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан дундаж зардал тогтмол өөрчлөгддөг тул энэ төрлийн түүвэр судалгааг 2-3 жилийн давтамжтай гүйцэтгэж, тооцооллыг шинэчлэх шаардлагатай байдаг. Энэ удаагийн судалгаагаар хувийн болон багцын аяллын дундаж зардлыг шинэчлэн тооцохын зэрэгцээ бусад зардлын дүн, түүний зарцуулалтын мэдээллийг олж авах, түүнийг үйлчилгээний дансны тооцоололд ашиглахыг зорилоо. Мөн түүвэр авах байршлыг өргөтгөсөн (Буянт-Ухаа, Алтанбулаг, Замын-Үүд хилийн боомтууд), тур оператор компаниудаас нэмэлтээр судалгаа авсан, салбарын яамны зүгээс аялал жуулчлалын салбарын бодлогын шийдвэрт дэмжлэг болгох зорилгоор тур оператор компаниудад тулгамдаж буй асуудлын талаар санал зөвлөмжийг агуулсан асуултуудыг тусгасан нь энэ удаагийн судалгааны онцлог байлаа.

2.2. Ерөнхий мэдээлэл

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл дэх аяллын үйлчилгээ, (сая ам.доллар)



Төлбөрийн тэнцлийн статистикаас хархад, Монгол улсын аялал жуулчлалын үйлчилгээний орлого буюу гадаадын иргэдээс хүлээн авсан орлогын хэмжээ нь манай иргэдийн гадаадад аялахдаа зарцуулсан зардлаас бага, цэвэр дүнгээр 2016 онд 166 сая ам.долларын алдагдалтай буюу ДНБ-ий 1.5%-тай тэнцэх хэмжээний гадаад валютыг аялал жуулчлалын шугамаар гадаадад зарцуулсан байна.

Хүснэгт 1. Дотоодын жуулчдын урсгал¹

Улс	2011	2014	2016
АНУ, Канад	5959	9175	10914
БНСУ	34720	40004	56243
БНХАУ	1038515	1141999	1218357
Европ	11778	18080	19202
ОХУ	181337	194479	498065
Тайланд	3724	4347	3724
Япон	5354	10564	14680
Бусад	93860	33243	29594
Нийт	1,375,247	1,451,891	1,850,779

Гадаад улсад зорчсон Монгол иргэдийн статистикаас үзвэл 2014-2016 оны хооронд дотоодын зорчигчдын тоо 27%-иар өссөн (2011 онтой харьцуулбал 35%-иар өссөн) байна. Улсаар нь авч үзвэл ОХУ-д зорчигчдын тоо 2.6 дахин өссөн, БНСУ, Японд зорчигчдын тоо 40 орчим хувиар өссөн байна.

2.3. Түүврийн оновчтой хэмжээ²

Түүврийн эх олонлогийг 2016 онд гадаад улсад зорчсон 1,850,779 зорчигчид гэж үзсэн бөгөөд үүнээс эх олонлогийг төлөөлөхүйц хамгийн оновчтой түүврийн хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай, +/- 3,5%-ийн алдааны хязгаартай байхаар сонгон тооцоолоход 784 гарч байна.

$$n_0 = \frac{(t)^2 * (p) * (q)}{d^2}$$

Энд, t = Студентийн t тархалтын критик утга; p = түүврийн тодорхой асуултад хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь. Судалгаа хийхээс өмнө энэ үзүүлэлт мэдэгдэхгүй бол 0.5 гэсэн тогтмол хэмжээг ашигладаг; q = түүврийн тодорхой асуултад хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь; d = алдааны хязгаар буюу түүврийн үр дүнд гарсан дундаж утга нь түүврийн хэмжээг Δ хувиар ихэсгэж, бууруулсан ч үр дүн нь ижил гарна гэсэн таамаглал.

Хүснэгт 2. Оновчтой түүврийн хэмжээний тооцоолол

№	Байриул	2016 онд гадаад улсад зорчсон Монгол иргэдийн тоо*. (N)	Түүврийн хэмжээ. (n)								Авсан түүвэр
			Итгэх завсар=95%				Итгэх завсар=99%				
			Ахиуц алдааны утга/Алдааны хязгаар				Ахиуц алдааны утга/Алдааны хязгаар				
			0.05	0.035	0.025	0.01	0.05	0.035	0.025	0.01	
1	Алтанбулаг	426,615	121	247	485	3,030	209	427	837	5,234	349
2	Замын-Үүд	842,711	239	489	958	5,986	414	844	1,654	10,339	120
3	Буянт-Ухаа	38,191	11	22	43	271	19	38	75	469	370
4	Хавирга	44,649	13	26	51	317	22	45	88	548	97
	Нийт	1,850,779	384	784	1,537	9,604	664	1,354	2,654	16,589	936

Эх сурвалж: ХХЕГ


2.4. Түүврийн хэмжээ, шинж чанар

Түүвэр судалгааны хүрээнд 2017 оны III улиралд Буянт-Ухаа (370), Алтанбулаг (349), Замын-Үүд (120), Хавирга (97) хилийн боомтуудаас нийт 936 зорчигчдоос анкетын аргаар мэдээлэл цуглуулсан. Мөн 2017 оны II улиралд 15 тур оператор компаниас авсан мэдээллийг харьцуулж үр дүнг тооцоолсон. Түүврийн хэмжээ нь өмнө тодорхойлсон хамгийн бага оновчтой түвшин болох 784-с их байна.

¹ ХХЕГ-ын мэдээ (хувийн болон жуулчлах зорилгоор зорчсон иргэдийн тоо)

² Оновчтой түүврийн хэмжээг тодорхойлох Кокраны арга

Дүрслэл 2. Эх олонлог болон түүврийн бүтцийн харьцуулалт



2016 онд гадаад улсад зорчсон Монгол иргэдийг улс орон, бүс нутгаар нь авч үзэхэд БНХАУ руу 66%, ОХУ руу 27%, БНСУ руу 3%, Япон улсруу 1% нь зорчсон байна. Түүвэрт хамрагдсан иргэдийн хувьд харгалзан 23%, 35%, 23%, 5%-ийг эзэлж байгаагаас үзэхэд түүврийн бүтэц нь эх олонлогийн бүтцээ төлөөлж чадахуйц, нийцтэй тархсаныг харуулж байна.

Ш. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ҮР ДҮН

3.1. Аяллын дундаж зардал

Монгол жуулчдын гадаад улс оронд аялах хугацаандаа буюу эдийн засгийн харьяат буст төлж буй дундаж зардал нь тухайн жуулчин аяллаа хэрхэн зохион байгуулсанаас гадна ямар улсад зорчиж байгаагаас хамаарч ялгаатай байдаг нь өмнөх судалгааны ажлуудаар тогтоогдсон. Жуулчдын дундаж зардлын хэмжээг тооцоход нийт 936 түүврээс статистик тооцооллын чанар хангаагүйг хасч, үлдсэн 923 түүврийг ашиглав.

Энэхүү судалгаанд хамрагдсан аялагчдын 17% нь тур оператор компаниар үйлчлүүлсэн бол үлдсэн 83% нь хувиараа аяллаа зохион байгуулсан байна. Судалгааны ажлын үр дүнд Монголчууд **12** орчим хоног олон улсад аялдаг бөгөөд дунджаар **1,576 ам.доллар** зарцуулж байна. Аялсан улс бүрээр дундаж зардлыг үзүүлсэн хүснэгт 3-с харахад АНУ, Канад улсуудад аялсан жуулчид хамгийн их, ОХУ-д аялагчид хамгийн бага зардлаар аялдаг байна. Манай улсаас ОХУ-д аялагчдын ихэнх нь Байгаль нуур, Итгэл хамбад бараалхах зорилгоор зорчдог бөгөөд байршлын хувьд ойр, өртөг харьцангуй хямд тул тус улсад зарцуулах зардал бусад улстай харьцуулбал бага дүнтэй байна. Мөн БНХАУ-д аялагчдын дундаж зардал харилцан адилгүй байдаг тул Замын-Үүд боомтоор болон Буянт-Ухаа боомтоор гэж ангилан тооцоолсон. Багцын аяллын аялагчид дунджаар 7 хоног, хувиараа аялагчид 18 хоног гадаадад аялдаг бөгөөд үүнээс шалтгаалан аяллын дундаж зардал 2.4 дахин ялгаатай байна.

Хүснэгт 3. Монгол Улсад зарцуулж буй аяллын дундаж зардал³

Улс, бүс	Дундаж хоног	Аяллын дундаж зардал		Дундаж зардал	Зардлын харьцаа (Багц/Хувийн)
		I. Багц аялал	II. Хувийн аялал		
АНУ, Канад	15	4000	3258	3280	1.2
БНСУ	30	1781	2416	2398	0.7
БНХАУ /Буянт-Ухаа/	5	1355	1441	1432	0.9
БНХАУ /Замын-Үүд/	2	916	1306	1252	0.7
ОХУ	3	434	858	710	0.5
Япон	5	2253	1706	1816	1.3
Европ	30	2099	3172	2828	0.7
Бусад	14	969	2780	2011	0.3
Нийт	12	746	1807	1576	0.4

Хүснэгт 4. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулсан байдал*⁴

Улс	2017	2014	ТТ*	2017/2014*	2017/ТТ*	Монголбанк, АЖҮТөв-тэй хамтран 2014 онд хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулбал, гадаадын жуулчдын Монгол Улсад аялахдаа зарцуулсан дундаж зардлын хэмжээ 3%-иар буурсан. Замын-Үүд хилийн боомтоор дамжин БНХАУ-д зорчигчдийн дундаж зардал 48%-иар өссөн нь хамгийн их өөрчлөлттэй байна.
АНУ, Канад	3280	2230	2918	47%	12%	
БНСУ	2398	1889	2788	27%	-14%	
БНХАУ /Буянт-Ухаа/	1432	1324	1777	8%	-19%	
БНХАУ /Замын-Үүд/	1252	843	843	48%	48%	
ОХУ	710	515	529	38%	34%	
Япон	1816	1566	2605	16%	-30%	
Европ	2828	1975	3051	43%	-7%	
Бусад	2011	1416	1705	42%	18%	
Нийт	1576	1622		-3%		


Мөн өмнө нь хийгдсэн судалгааны түүвэр авсан байршил нь хязгаарлагдмал (Буянт-Ухаа) тул өртөг өндөр жуулчид ихээр хамрагдсан байх магадлалтай, мөн сүүлийн жилүүдийн төгрөгийн эсрэг ам.долларын чангаралтай холбоотой аяллын зарцуулалтын дүн буурахад тодорхой нөлөө үзүүлсэн байж болзошгүй юм.

Одоогийн төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд ашиглаж буй дүнгээс харилцан адилгүй ялгаатай гарч байгаа нь энэ төрлийн тоон мэдээллийг тогтмол шинэчлэх шаардлагатайг харуулж байна.


³ Үүнд олон улсын нислэг, тээвэр орохгүй.

⁴ 2005 болон 2014 оны судалгааны үр дүн болон инфляциар засварласан төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд ашиглаж буй үр дүн

Дүрслэл 3. Хувиараа аялагчдын зардлын бүтэц




Дүрслэл 4. Багц аялагчдын зардлын бүтэц




Хувиараа аялагчдын зарцуулсан зардлын бүтцийг авч үзвэл нийт зардлын дунджаар 31%-ийг барааны худалдаанд, 20%-ийг орон байр, зочид буудлын үйлчилгээнд, 19%-ийг хоолны газрын үйлчилгээнд зарцуулдаг байна. Харин багц аялагчдын хувьд нийт зардлынхаа 59%-ийг жуулчлалын компанид төлдөг бөгөөд тухайн төлбөрт байр, орон сууц (19%⁵), хоолны газрын (5%), орон нутгийн тээврийн (7%), үзвэр үйлчилгээний зэрэг бусад үйлчилгээний (28%) зарим төлбөрүүд багтдаг байна. Мөн БНСУ-д жуулчлах зорилгоор зорчсон иргэд нийт зардлынхаа 18%-ийг эрүүл мэндийн үзлэгт, Япон улсад аялагчид зардлынхаа 21%-ийг орон байр, зочид буудлын үйлчилгээнд төлдөг байна.

Дүрслэл 5. Аяллын үндсэн зорилго



Дүрслэл 6. Төлбөр тооцооны хэлбэр



Төлбөр тооцооны хэлбэрийг авч үзвэл 15% нь олон улсын карт ашигладаг, 76% нь бэлнээр төлбөрөө хийдэг бол үлдсэн 9% нь хосолмол байдлаар ашигладаг байна. Энэ нь 2014 онд хийгдсэн судалгаатай харьцуулахад төлбөр тооцооны хэлбэрт төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

⁵ Нийт дундаж зардалд эзлэх хувь

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар гадаадад аялсан Монгол жуулчдын дундаж зардал, түүний зарцуулалтын задаргааг шинэчлэн тооцсон нь цаашид төлбөрийн тэнцэл, аялал жуулчлалын статистикийн чанарыг сайжруулах ач холбогдолтой боллоо.

Гадаадад аялсан иргэдийн хувьд аялсан улс орноосоо хамаарч зардлууд нь харилцан адилгүй дунджаар 12 хоногт 1,576 ам.доллар зарцуулдаг ба энэ нь Монголбанкнаас 2014 онд хийсэн судалгааны үр дүнгээс 3%-иар буурсан үзүүлэлт юм.

Мөн жуулчдын 17% нь жуулчны компаниар үйлчлүүлсэн, 83% нь хувиараа аяллаа зохион байгуулсан бөгөөд аялагчдын 76% нь бэлнээр, 15% нь картаар, үлдсэн 35%-ийг хосолмол байдлаар төлбөр тооцоогоо гүйцэтгэдэг байна. Нийт зарцуулалтын 33 орчим хувийг барааны худалдаанд, 20%-ийг орон байр, зочид буудлын үйлчилгээнд, 19%-ийг ресторан, хоолны газрын үйлчилгээнд зарцуулдаг байна.

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд аяллын дансны зарлагыг энэхүү үр дүнгээр шинэчлэн тооцох, эдийн засгийн өөрчлөлт, гадаад харилцаа өргөжин тэлж байгаатай холбогдуулан энэхүү түүвэр судалгааг 2 жилд нэг удаа зохион байгуулж, дундаж зардлын дүнг шинэчилж байх саналтай байна.